

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН,ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.2 Авлага	12
3.5.3 Урьдчилгаа	12
3.5.6 Бараа материал	13
3.5.7 Үндсэн хөрөнгө	13
3.5.8 Өр төлбөр	14
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо	14
3.5.10 Зардлын данс	15
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	15
3.7 Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	17
Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	17
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	18
4. Менежментийн захидал	19
3.2 Харьяа байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой асуудал	19
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХАБҮЛ	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Т.ГАНТУЛГА ТАНАА

додг. 03.05 № 07/1001
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 63 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 89.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,766,091.1	6,711,453.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	374,856.3	344,370.3
33	АВЛАГА	39,559.4	72,007.1
34	УРЬДЧИЛГАА	11,200.0	65.0
35	БАРАА МАТЕРИАЛ	2,943,036.8	6,295,011.3
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	3,397,438.7	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	31,563,294.6	37,684,496.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	31,563,294.6	37,684,496.8
39200	Биет хөрөнгө	29,650,301.8	35,785,783.7
39300	Биет бус хөрөнгө	1,912,992.8	1,898,713.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	38,329,385.7	44,395,950.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	331,297.2	296,187.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	331,297.2	296,187.6
41300	Өглөг	331,297.2	296,187.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	37,998,088.5	44,099,762.9
51	Засгийн газрын хувь оролцоо	37,998,088.5	44,099,762.9
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,432,657.	16,447,971.3
51200	Хуримтлагдсан үр дүн	18,587,867.2	24,793,074.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,977,564.0	2,858,717.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	38,329,385.7	44,395,950.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	45,119,165.1	55,638,378.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,623,931.1	7,330,911.8
120	Нийтлэг татварын бус орлого	7,623,931.1	7,330,911.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	37,495,234.0	48,307,466.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	42,355,457.	49,457,190.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,355,457.5	49,457,190.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35,314,082.6	43,789,142.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,016,021.1	26,997,031.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,791,155.	3,412,920.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,620,712.1	1,869,670.2
2104	Хангамж, бараа материалын зардал	1,263,106.0	2,544,924.2
2105	Нормативт зардал	532,882.7	1,017,789.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	343,180.0	1,293,463.8
2107	Томилолт, зочны зардал	490,045.8	614,837.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	712,921.7	823,657.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,544,057.8	5,214,846.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,041,375.0	5,668,048.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,763,707.6	6,181,187.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	278,930.4	92,631.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,484,777.2	6,088,555.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	42,073,207.8	52,059,171.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,572,757.1	3,715,642.7
120	Нийтлэг татварын бус орлого	4,572,757.1	3,715,642.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	37,500,450.7	48,343,528.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,475,051.3	48,811,276.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,475,051.3	48,811,276.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,511,514.2	41,900,188.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,010,581.7	27,009,048.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,791,103.2	3,399,752.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,623,102.0	1,869,679.8
2104	Хангамж, бараа материалын зардал	1,189,761.2	1,784,030.1
2105	Нормативт зардал	842,432.2	1,597,143.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	441,023.5	2,903,975.5
2107	Томилолт, зочны зардал	486,945.9	618,629.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	778,634.3	903,872.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	347,930.2	1,814,057.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,963,537.1	6,911,087.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,598,156.5	3,247,895.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,372,560.5	3,278,381.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,372,560.5	3,278,381.1
2200	Дотоод эх үүсвэрээр	3,372,560.5	3,278,381.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,372,560.5	-3,278,381.1
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	225,596.0	-30,486.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	149,260.2	374,856.3
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	374,856.3	344,370.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,518,971.2	35,518,971.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	25,866.7	25,866.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,544,837.9	35,544,837.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-31,526.6	-31,526.6
9	Тайлант үеийн үр дүн	2,484,777.2	2,484,777.2
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,998,088.5	37,998,088.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	116,651.2	116,651.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,114,739.7	38,114,739.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-163,266.4	-163,266.4
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	59,734.0	59,734.0
19	Тайлант үеийн үр дүн	6,088,555.6	6,088,555.6
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	44,099,762.9	44,099,762.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,932,379,000.0	42,418,545,415.7	3,513,833,584.2	92.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,461,379,000.0	41,130,165,416.2	1,331,213,583.7	96.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,834,923,100.0	39,629,479,003.2	1,205,444,096.7	97.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,898,461,600.0	26,327,969,189.3	570,492,410.6	97.8
210101	Үндсэн цалин	19,686,060,800.0	19,230,609,785.8	455,451,014.1	97.6
210102	Нэмэгдэл	5,585,282,500.0	5,595,089,528.2	-9,807,028.2	100.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,292,118,400.0	1,262,759,822.0	29,358,577.9	97.7
210104	Урамшуулал	334,999,900.0	239,510,053.2	95,489,846.7	71.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,664,140,700.00	3,366,922,027.3	297,218,672.6	91.8
210201	Тэтгэврийн даатгал	2,554,551,400.0	2,360,538,871.1	194,012,528.8	92.4
210202	Тэтгэмжийн даатгал	277,397,000.0	255,397,025.5	21,999,974.4	92.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	221,918,500.0	198,738,090.1	23,180,409.8	89.5
210204	Ажилгүйдлийн даатгал	55,478,900.0	51,046,949.3	4,431,950.6	92.0
210205	Эрүүл мэндийн даатгал	554,794,900.0	501,201,091.1	53,593,808.8	90.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,896,684,100.0	1,845,443,903.4	51,240,196.5	97.3
210301	Гэрэл, цахилгаан	273,607,700.0	262,236,618.0	11,371,081.9	95.8
210302	Түлш, халаалт	924,389,200.0	900,426,865.6	23,962,334.3	97.4
210303	Цэвэр, бохир ус	149,604,500.0	136,976,750.7	12,627,749.2	91.5
210304	Байрны түрээс	549,082,700.0	545,803,669.0	3,279,031.0	99.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,793,502,300.0	1,743,494,283.3	50,008,016.6	97.2
210401	Бичиг хэрэг	423,136,100.0	418,968,745.0	4,167,355.0	99.0
210402	Тээвэр, шатахуун	777,738,100.0	759,692,115.0	18,045,985.0	97.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	324,772,800.0	316,394,733.3	8,378,066.6	97.4
210404	Ном, хэвлэл	-	15,000.0	-15,000.0	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,839,600.0	12,121,186.0	2,718,414.0	81.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	253,015,700.0	236,302,504.0	16,713,196.0	93.3
2105	Нормативт зардал	1,347,380,500.0	1,327,572,482.7	19,808,017.2	98.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,228,396,900.0	1,213,802,110.7	14,594,789.27	98.81
210502	Хоол, хүнс	99,577,600.0	96,119,993.0	3,457,607.0	96.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,406,000.0	17,650,379.0	1,755,621.0	90.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,474,700.0	3,367,453,430.0	103,021,270.0	97.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	716,016,300.0	704,434,944.00	11,581,356.0	98.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,374,086,400.0	2,298,918,531.0	75,167,869.0	96.8
210604	Урсгал засвар	375,372,000.0	359,099,955.0	16,272,045.0	95.6
2107	Томилолт, зочны зардал	673,365,300.0	602,107,017.0	71,258,283.0	89.4
210702	Дотоод албан томилолт	673,365,300.0	602,107,017.0	71,258,283.0	89.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,032,653,100.0	991,886,280.0	40,766,819.9	96.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	484,960,000.00	464,092,682.0	20,867,317.9	95.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	41,737,300.0	37,822,076.0	3,915,224.0	90.6
210803	Даатгалын үйлчилгээ	37,086,200.0	35,070,054.0	2,016,146.0	94.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	11,879,700.0	10,060,852.0	1,818,848.0	84.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,775,500.0	2,529,300.0	246,200.0	91.1

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	303,971,200.0	299,277,353.0	4,693,847.0	98.4
210807	Газрын төлбөр	12,120,600.0	9,797,862.0	2,322,738.0	80.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	138,122,600.0	133,236,101.0	4,886,499.0	96.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,260,800.0	56,630,390.0	1,630,410.0	97.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	58,260,800.0	56,630,390.0	1,630,410.0	97.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,626,455,900.0	1,500,686,413.0	125,769,487.0	92.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,626,455,900.0	1,500,686,413.0	125,769,487.0	92.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,414,559,400.0	1,293,967,619.0	120,591,781.0	91.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	167,896,500.0	162,718,794.0	5,177,706.0	96.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,471,000,000.0	1,288,379,999.5	2,182,620,000.5	37.1
220001	Барилга байгууламж	3,471,000,000.0	1,288,379,999.5	2,182,620,000.5	37.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,932,379,000.0	42,418,545,415.7	3,513,833,584.2	92.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,619,424,000.0	42,105,590,415.7	3,513,833,584.2	92.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	45,619,424,000.0	42,105,590,415.7	3,513,833,584.2	92.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10,000.0	-10,000.0	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,000.0	-10,000.0	

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,939,027,005.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,103,807,755.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,224,621,197.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,079,708.4
210101	Үндсэн цалин	263,012,798.4
210102	Нэмэгдэл	40,349,910.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,517,000.0
210104	Урамшуулал	373,200,000.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,829,993.2
210201	Тэтгэврийн даатгал	32,829,993.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,235,872.2
210301	Гэрэл, цахилгаан	4,645,872.2
210302	Түлш, халаалт	250,000.0
210303	Цэвэр, бохир ус	19,340,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	54,643,065.0
210401	Бичиг хэрэг	6,497,700.0
210402	Тээвэр, шатахуун	34,858,520.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,300,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,986,845.0
2105	Нормативт зардал	301,833,136.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	244,950,870.0
210502	Хоол, хүнс	9,250,766.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	47,631,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	277,130,222.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	71,166,000.0
210602	Тавилга	11,132,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	176,350,890.0
210604	Урсгал засвар	18,481,332.0
2107	Томилолт, зочны зардал	16,522,000.0
210702	Дотоод албан томилолт	16,522,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,871,660.0

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81,772,400.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	99,260.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,754,475,540.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,753,307,940.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,167,600.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	879,186,557.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	612,680,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,200,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	585,480,000.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	266,506,557.9
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	31,929,057.9
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	234,577,500.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	835,219,250.0
2200	Дотоод эх үүсвэрээр	835,219,250.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	835,219,250.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,939,027,005.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,939,027,005.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	95,912,680.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,800,808,872.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	411,496,890.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,630,808,563.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Т.Гантулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгийг ашиглах талаар шийдвэр гаргах, харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахтай холбоотой асуудлуудыг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-аас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор П.Амарсанаа, Э.Энхбаатар, гэрээт ажилтан М.Ганбаатар нар гүйцэтгэв.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/499 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийг сахиулан, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын эрхэм зорилго оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Мэргэжлийн хяналтын талаарх хууль тогтоомж, хяналт шалгалтын бодлого, стратегийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах;
- Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх таатай орчныг бий болгоход үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн төрийн захиргааны мэргэжлийн хяналтыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх;
- Төрийн захиргааны удирдлагыг хангах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх.
- Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, тэдгээрийг боловсронгуй болгох;
- Хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилтийг хангах, дотоод хяналтыг зохион байгуулах;
- Мэргэжлийн хяналтын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалтын стандарт, нийтлэг шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох;
- Нэгдсэн болон орон нутаг, хилийн лабораториудыг шинэ дэвшилтэт техник, технологиор хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх;

- Нарийн мэргэжлийн шинжээчдийг ажиллуулах эрхзүйн болон эдийн засгийн үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх;
- Иргэдийг эрүүл аюулгүй бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллээр хангах, хууль тогтоомжийг нийтийн хүртээл болгох;
- Байгууллага, аж ахуйн нэгжийн дотоод хяналтын эрхзүйн орчинг боловсронгуй болгох, мэргэжлийн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх;
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, нарийн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, байгууллагын зорилт, чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх цомхон, чадварлаг боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх;
- Мэргэжлийн хяналтын хууль эрхзүйн орчинг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн зохион байгуулах;
- Ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн зохион байгуулах, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах;
- Гадаад орон, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээллийн технологийн удирдлагыг нэвтрүүлэх.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь 2020 оны төсвийн жилд Хууль зүй, мониторингийн хэлтсийн шалгалтын төлөвлөгөөний дагуу орон нутгийн төсвийн захирагч нарт дотоод хяналт, шалгалт хийсэн. Мөн МХЕГ-т тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад “бага” гэж үнэллээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт орлого 55,638.3 сая төгрөгийн 2 хувь буюу 1,112.7 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 374.8 сая, эцсийн үлдэгдэл 344.3 сая төгрөг болж, 30.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	0.3	0.01	-0.3	1.0
Банканд байгаа бэлэн мөнгө	374.5	344.3	-30.1	99.0
Дүн	374.8	344.3	-30.4	100.0

Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 344.1 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 0.1 сая төгрөг арилжааны банк дахь харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 39.5 сая, эцсийн үлдэгдэл 72.0 сая төгрөг болж, 32.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.1	9.2	9.1
Байгууллагаас авлага	37.0	60.4	23.3
Хувь хүмүүсээс авсан авлага	2.3	2.3	-
Дүн	39.5	72.0	32.4

Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 35.3 сая төгрөгийн авлагаас 11.8 сая төгрөгийн 2006-2016 онуудад үүссэн 47 хувь хүн, аж ахуй нэгж, байгууллагын эзэн холбогдогч тодорхойгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлага байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагатай холбоотой нийт 24.2 сая төгрөгийн дараах зөрчлүүд байна.

- Сэлэнгэ аймгийн МХГ эзэн холбогдогч нь тодорхой бус гэсэн шалтгаанаар 2006 онд үүссэн 0.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.
- Хүнсний аюулгүй байдал, үндэсний лавлагаа лабораторийн авлага өглөгийн дансны үлдэгдлийг тооцооны үлдэгдлийн баталгаатай тулган шалгахад харилцагч нь тодорхойгүй 23.5 сая төгрөгийн авлага байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 11.2 сая, эцсийн үлдэгдэл 1.0 сая төгрөг болж, 11.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	11.0	-	-11.0
Цалингийн урьдчилгаа	0.2	1.0	-0.8
Дүн	11.2	1.0	-11.8

Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 1.0 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 2,943.0 сая, эцсийн үлдэгдэл 6,295.0 сая төгрөг болж, 3,351.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	142.2	127.3	-15.0
Эм боох материал	355.6	875.5	519.9
Бэлэн бүтээгдэхүүн	85.3	156.5	71.2
Хангамжийн материал	2,358.5	5,134.4	2,775.9
Мал амьтан	1,131.3	1,131.3	-
Дүн	2,943.0	6,295.0	3,351.9

Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын бараа материал тайлант онд 2,775.9 сая төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөц бэлтгэсэнтэй холбоотой байна. Үүнд: Улаанбаатар дахь Мэргэжлийн хяналтын газар 1,449.2 сая, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар 927.4 сая, ХАБҮЛ лаборатори 408.7 сая, Замын-Үүд хилийн боомтын МХГ 279.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 3.397.4 сая төгрөгийн 2 барилга бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байсныг Төрийн өмчийн, бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр Завхан, Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газарт шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалтай холбоотой нийт 113.5 сая төгрөгийн дараах зөрчлүүд байна.

- ХАБҮЛ лабораторид хуучирсан, ашиглагддаггүй 31.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй.
- Хөвсгөл аймгийн МХГ нь төлбөрийн баримтгүй 62.6 сая төгрөгийн худалдан авалт хийсэн.
- Дорноговь аймгийн МХГ нь дээд шатны байгууллагын зөвшөөрөлгүйгээр ААН-ээс бараа материал хандиваар авсан.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 31,563.2 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 37,684.4 сая төгрөг болж 6,121.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	20,014.94	26,307.48	6,292.5
Авто-тээврийн хэрэгсэл	1,045.06	1,821.23	776.1
Машин тоног төхөөрөмж	6,092.28	4,771.32	-1,320.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,015.57	953.29	-62.2
Зам, гүүрний байгууламж	4.95	3.98	-0.9
Бусад үндсэн хөрөнгө	1,417.63	1,876.48	458.8
Дуусаагүй барилга, байгууламж	52.96	52.00	-0.9
Ном	6.90	-	-6.9
Биет бус хөрөнгө	1,912.99	1,898.71	-14.2
Дүн	31,563.27	37,684.50	6,121.2

Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны барилга, байгууламж 6,292.5 сая төгрөгөөр голлон өссөн шалтгаан нь 2018-2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон дараах барилгыг данс бүртгэлд эрх бүхий байгууллагын шийдвэрээр бүртгэсэн байна. Үүнд:

- ТӨБЗГ-ын 2020 оны 448 дугаар тогтоолын дагуу Говь-Алтай аймгийн МХГ 1,327.6 сая төгрөг;
- ТӨБЗГ-ын 2020 оны 745 дугаар тогтоолын дагуу Завхан аймгийн МХГ 2,289.0 сая төгрөг;
- ТӨБЗГ-ын 2020 оны 543 дугаар тогтоолын дагуу Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын лаборатори 3,253.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Авто тээврийн хэрэгсэл 1,324.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 205.0 сая төгрөг, балансаас шилжүүлж 431.6 сая төгрөг, шинээр худалдаж авсан 687.8 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгджээ.

Дуусаагүй барилга дансанд Говьсүмбэр, Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газруудын лабораторийн болон албан конторын 55,0 сая төгрөгийн зураг төсөв бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөтэй холбоотой нийт 70.8 сая төгрөгийн дараах зөрчлүүд байна.

- Завхан аймгийн МХГ нь үндсэн хөрөнгө, бараа материалын баримтын эмх цэгц хангалтгүй, бараа материалыг зөв ангилж бүртгээгүй, албан хаагчдын хөрөнгийн картыг шинэчлээгүй.
- Замын үүд боомт дахь МХГ нь биет бус хөрөнгийн дансанд 53.8 сая төгрөгийн зураг төсөв бүртгэлтэй байна. Энэ зургийн ажил нь Гаалийн цогцолборын хажууд шинэ албан байр барихаар хийлгэсэн боловч ашиглалтгүй.
- Говь-Алтай аймгийн МХГ нь жилийн эцсийн тооллогын комисс, 17.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө /вагончик/ бодитоор ирээгүй байхад тоолсон, нягтлан бодогч хөрөнгөд бүртгэсэн.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 331.2 сая, эцсийн үлдэгдэл 296.1 сая төгрөг болж, 44.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	331.2			
Ажилчидтай холбогдсон өглөг	0.1	4.8	4.7	10.5
Байгууллагад төлөг өглөг	331.1	291.3	39.8	89.5
Нийт дүн	331.2	296.1	44.5	100.0

Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 4.8 сая төгрөгийн ажилчидтай холбогдсон өглөг, 291.3 сая төгрөгийн байгууллагад төлөх өр байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 37,998.0 сая, эцсийн үлдэгдэл 44,099.7 сая төгрөг болж, 6,101.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,432.6	16,447.9	15.3	0.3
Хуримтлагдсан үр дүн	18,587.8	24,793.0	6,205.2	101.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,977.5	2,858.7	-118.8	-1.9
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
Дүн	37,998.0	44,099.7	6,101.7	100.0

Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 16,432.6 сая төгрөг болж 15.3 сая төгрөгөөр өссөн нь Дорнод аймгийн МХГ-ын 21.2 сая төгрөгийн шинэ барилгын газрын эзэмших эрхийг дансанд бүртгэсэн, Өвөрхангай аймгийн МХГ шилжүүлсэн барилгын дансны үнийн зөрүү 44.4 сая, шинэ барилгын газрын эзэмших эрх 38.4 сая төгрөгийг дансанд бүртгэснээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 2,977.5 сая төгрөг болж 118.8 сая төгрөгөөр буурсан нь Баянхонгор аймгийн МХГ 0.05 сая, Завхан аймгийн МХГ 91,975.9 сая, Өвөрхангай аймгийн МХГ 24,759.7 сая, Сэлэнгэ аймгийн МХГ 1.8 сая, Увс аймгийн МХГ 0.1 сая, МХЕГ 0.1 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээ хийснээс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 18,587.8 сая төгрөг болж 6,205.2 сая төгрөгөөр өссөн нь Завхан аймгийн МХГ нь 2,289.0 сая, Говь-Алтай аймгийн МХГ 1,327.6 сая, Өмнөговь аймгийн МХГ 3,253.5 сая төгрөгийн шинээр ашиглалтад орсон барилгыг данс бүртгэлд авснаас нөлөөлжээ.

3.5.8 Зардлын данс

Зардлын дансадтай холбоотой төсвийг үр ашиггүй, зориулалт бус, үрэлгэн зарцуулсан 51.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Зардлын данстай холбоотой нийт 51.0 сая төгрөгийн дараах зөрчлүүд байна.

- Дорноговь аймгийн МХГ нь томилолтын зардлын дээд хэмжээг хэтрүүлэн, 1.9 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.
- Завхан аймгийн МХГ нь албан хаагчдын цалин 4.0 сая төгрөгийг амралтын цалинтай давхардуулан олгосон, томилолтын хуудас харилцагч байгууллагын тамга, тэмдгээр баталгаажаагүй, очсон, явсан огноо бичигдээгүй баримттай 7.5 сая төгрөгийн зардал гаргасан.
- Орхон аймгийн МХГ нь дээд шатны төсөв захирагчийн зөвшөөрөлгүй 2.1 сая төгрөгийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан.
- Ховд аймгийн МХГ нь хүүхдээ асрах чөлөөтэй байсан албан хаагчдад 10.6 сая төгрөгийн цалин, зах зээлийн үнээс өндөр дүнгээр 1.2 сая төгрөгийн шатахуун, томилолтоор ажилласан эсэхийг нотлох боломжгүй 1.9 сая төгрөг, оны эцэст хуурамч бичиг баримт бүрдүүлэн 4.3 сая төгрөгийн томилолтын зардлуудыг тус тус олгосон байна.
- Сэлэнгэ аймгийн МХГ нь ур чадварын нэмэгдэл үндэслэлгүй 17.5 сая төгрөг олгосон.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Тайлант онд 3,850.0 сая төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 4,301.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 11.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Ариутгал хураамжийн орлого	1,764.2	945.7	-818.5	53.6
Лабораторийн шинжилгээний орлого	1,385.8	2,404.5	1,018.7	173.5
Бусад/ Орон нутагт төвлөрүүлэх гэрчилгээ, мэдэгдлийн төлбөр.		167.0	167.0	
Хяналт шалгалтын орлого	700.0	784.3	84.3	112.0
Нийт дүн	3,850.0	4,301.5	1,270.0	111.7

Ариутгал хураамжийн орлого 818.5 сая төгрөгөөр тасарсан нь Ковид-19 цар тахлын үед хилийн хяналтын боомтуудын үйл ажиллагаа зогссонтой холбоотой импортын бараа,

бүтээгдэхүүний ариутгал хураамж буурснаас шалтгаалсан байна. Лабораторийн шинжилгээний орлого тайлант онд 1,018.7 сая төгрөгөөр давсан нь аж ахуй нэгж, байгууллага бараа, бүтээгдэхүүндээ шинжилгээ хийлгүүлэх тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардал, санхүүжүүлэх эх үүсвэрийг 44,443.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс байр ашиглалттай холбоотой зардлыг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 44,543.9 сая төгрөгөөр баталсан. Мөн тайлант онд төсвийн тодотголоор 1,388.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 45,932.3 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 4 арга хэмжээнд зориулан 45,932.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 42,461.3 сая төгрөгийг урсгал зардалд, 3,471.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 45,619.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 312.9 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 42,105.5 сая төгрөгийг, нийт 3,513.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна. Мөн үндсэн үйл ажиллагааны төлөвлөсөн орлогын гүйцэтгэл 312.9 сая төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 42,418.5 сая төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 570.4 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийг 297.2 сая, байр ашиглалттай холбоотой зардал 51.2 сая, хангамж, бараа материалын зардал 50.0 сая, норматив зардал 19.8 сая, эд хогшил, урсгал засварын зардал 103.0 сая, томилолтын зардал 71.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ төлбөр хураамжийн зардал 40.7 сая, бараа үйлчилгээний бусад зардал 1.6 сая, Урсгал шилжүүлэг 125.7 сая, хөрөнгийн зардал 2,182.6 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 1,331.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 6 төсөл, арга хэмжээнд 3,471.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,288.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар Говь-алтай аймгийн МХГ-т Дэлхийн байгаль хамгаалах сангаас 6.2 сая, Увс аймгийн МХГ-т Дэлхийн байгаль хамгаалах сангаас 17.3 сая, Өмнөговь аймгийн МХГ-т Улаан загалмай нийгэмлэгээс 70.9 сая, Замын-Үүд боомтын МХГ-т БНХАУ-ын Замын-Үүд дахь Консулын газраас 1.6 сая, нийт 95.9 сая төгрөгийн хандив өгсөн байна. Засгийн газрын нөөц сангаас 2,800.8 сая, дээд шатны төсвийн захирагчаас 2,762.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,630.8 мянга, нийт 7,289.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 681.0 сая, ажил олгогчоос НДШ-д төлөх зардалд 33.0 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 24.2 сая, Хангамж бараа материалын зардалд 54.6 сая, норматив зардалд 302.0 сая, эд, хогшил урсгал засварын зардалд 277.1 сая, томилолт зочны зардалд 16.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн, ажил

үйлчилгээ төлбөрт 81.8 сая, бараа, үйлчилгээний бусад зардалд 1,754.4 сая, урсгал шилжүүлэг 612.6 сая, хөрөнгийн зардалд 835.2 сая, нийт 4,672.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 266.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 143 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроосон, 4 мэдээллийн хугацаа болоогүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 15.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 21.4 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөгөөр/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	15.5	1	15.5			100.0
Албан шаардлага							
Зөвлөмж	4	21.4	4	21.4			100.0
Нийт	5	36.9	5	36.9			100.0

3.9. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 27 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 26 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 25 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Ховд аймгийн мэргэжлийн хяналтын газарт “Сөрөг” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 5.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 5.2 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлээ.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын тушаалаар албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халсан болохыг шүүх тогтоосон бөгөөд ажилгүй байсан хугацааны цалин 5.2 сая төгрөгийг төсвийн хөрөнгөөс нөхөн олгосон байна.

Шийдвэрлэсэн: Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-т "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж

хариуцна" гэж заасныг үндэслэн. Төрд учруулсан хохирлыг албан тушаалтнаас шаардан гаргуулж, төлүүлэх. Мөн МХЕГ-ын Хууль, зүй мониторингийн хэлтэст хуульд заасан үүргээ хэрэгжүүлэн ажиллах талаар албан шаардлага хүргүүлж байна.

2. Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар "Сөрөг" санал дүгнэлт өгсөн байна.

Шийдвэрлэсэн: Төрийн аудитын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасныг үндэслэн Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төсвийн захирагчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг МХЕГ-ын Хууль, зүй мониторингийн хэлтэст хүргүүлж байна.

Төвлөрүүлэн захирагчид илэрсэн алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,178.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,899.6 сая төгрөгийн 30 алдааг аудитын явцад залруулж, 31.0 сая төгрөгийн 11 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 112.4 сая төгрөгийн 29 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 135.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 29 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын олон жилийн насжилттай 47 хувь хүн, байгууллагаас авах 11.8 сая төгрөгийн авлагыг хэрхэн барагдуулах талаар ямар ажил зохион байгуулж ажилласан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Дээрх авлага нь хөөн хэлэлцэх хугацаа дууссан, нас барсан иргэн, дампуурсан компани, хаяг тодорхойлох боломжгүй иргэн, аж ахуй нэгжтэй учраас авах авлагыг удаа дараа хуулийн байгууллагад хүсэлт хүргүүлсэн ч шийдвэрлэгдээгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглах хугацаа дууссан 2 автомашиныг ашиглаж байгаа боловч хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

4.1.2 Эрсдэл: Санхүүгийн тайланд ашиглалтын хугацаа дуусаан хөрөнгө бүртгэлтэй, эрх бүхий байгууллагын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахгүй байх.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн бодлого. Зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтыг хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн, бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байгаа тул Ашиглалтын хугацаа үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4.2 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.2.1 Илрүүлэлт: Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 27 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 25 санхүүгийн тайлан зөрчилгүй, 1 санхүүгийн тайлан сөрөг, 1 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитаар нийт 3,178.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,899.6 сая төгрөгийн 30 алдааг аудитын явцад залруулж, 31.0 сая төгрөгийн 11 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 112.4 сая төгрөгийн 29 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 135.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 29 зөвлөмжийг хүргүүлээ.

4.2.2 Эрсдэл: Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх.

4.2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-т “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг мөрдөж ажиллах, харьяа газруудад илэрсэн зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.03.25	Аудитын нэр:	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/4/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглах хугацаа дууссан 2 автомашиныг ашиглаж байгаа боловч хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	-	Зөвлөмж	Дарга, Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч	Т.Гантулга Ж.Болормаа А.Дайриймаа
2	Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын тушаалаар үндэслэлгүй халсан ажилтанд цалин 5.2 сая төгрөгийг цалинг төсвөөс олгосон байгаа нь “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.	5.2	Албан шаардлага	Сүхбаатар аймгийн МХГ-ын дарга	С.Сарантуяа
3	Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 27 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 25 санхүүгийн тайлан зөрчилгүй, 1 санхүүгийн тайлан сөрөг, 1 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитаар нийт 3,178.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,899.6 сая төгрөгийн 30 алдааг аудитын явцад залруулж, 31.0 сая төгрөгийн 11 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 112.4 сая төгрөгийн 29 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 135.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 29 зөвлөмжийг хүргүүллээ.	-	Зөвлөмж	Дарга, Хууль зүй, мониторингийн хэлтсийн дарга, Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч	Т.Гантулга, Б.Бакыт Ж.Болормаа А.Дайриймаа
4	Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.	-	Албан шаардлага	Ховд аймгийн МХГ-ын дарга	П.Эрдэнэчулуун
	Дүн	5.2			

2021 оны 03 дугаар сарын 25

№ 457/9017 0064

Улаанбаатар хот

CAT-2021/4/CTA-TT3

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2020 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар "Сөрөг" санал дүгнэлт авсан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар сөрөг санал дүгнэлт авсан Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Л.Эрдэнэчулуунд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
1. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Хууль зүй, мониторингийн хэлтсийн дарга Т.Бакыт нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

П.АМАРСАНАА

Э.ЭНХБААТАР

2021 оны 03 дугаар сарын 25

№ 453/А017 0064

CAT-2021/4/CTH-TT3

Зөрчил арилгах тухай

Э.ЭНХБААТАР

[illegible]